

**ТУСГААР ТОГТНОЛ ЭВ НЭГДЛИЙН НАМ МОНГОЛЫН НОГООН НАМЫН  
“ТУСГААР ТОГТНОЛ ЭВ НЭГДЭЛ” ЭВСЛИЙН “АРД ТҮМНИЙ ИТГЭЛ  
НАЙДВАР-ЦЭВЭР ТӨР” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**НЭГДМЭЛ АРД ТҮМЭН ЯЛАГДАШГҮЙ !**

Өнөөгийн түүхэн цаг үеийн тулгамдсан дуудлагад хариулахаар зориг шулуудаж, үзэл санаа, хүсэл зоригороо эвлэлдэн нэгдсэн бидний хүмүүс “Тусгаар тогтнол эв нэгдэл” Эвсэл байгуулан 2016 оны УИХ-ын сонгуульд оролцох Мөрийн Хөтөлбөрөө ард түмэндээ толилуулж байна.

Хэрэв эрх баригч хүчин үүрэг хариуцлагаа умартан, төр болон нийгмийг удирдах чадвараа бүрэн гээж, нийгмийг хямрал мухардалд оруулж, чингэхдээ олон арван жилийн турш ард түмнээ хууран мэхэлж ирсэн тохиолдолд түүнийг халж орлох улс төрийн шинэ хүчин төрдөг нь аль ч нийгмийн жам юм. Өнөөдөр тэр цаг нь болж, Монголын ард түмэн өнөө болон хойч үеийнхээ өмнө, монгол үндэстнийхээ өмнө хариуцлага хүлээх чадвартай, ирж буй шинэ цагийн дуудлагыг хэрэгжүүлж чадах улс төрийн шинэ хүчнийг хүсэн хүлээх болов.

**Монголчууд бид сэтгэлгээ, үйлдлийнхээ саад тогторыг давж, үндэсний хийгээд нийгмийн эрх ашгаа ухамсарлан, орчин үеийн тэргүүний үзэл санаанд тулгуурлан, цаг үеийн жам ёс, хандлагад нийцүүлэн, Монгол үндэстний оршихуйн шинэ замыг тодорхойлох САЙН ЦАГ ИРЛЭЭ.**



Монголчууд бид Сайн цагийн зайлшгүй түүхэн хандлагыг наашлуулахын тулд ухаарч сэхээрэн, эргэцүүлэн бодож, шинээр сэтгэж үйлдэн муу муухайг зайлцуулж, ирээдүйн сайн үйлийг бүтээж, үүний тулд нийгмийн өндөр идэвхи гарган, нэгдэн нягтарч, хамтран зүтгэх шинэ үйлсийг эхлүүлэх цаг үеийн дуудлагад бид хариулж байна.

**НЭГ. БИДНИЙ ЗОРИЛГО**

**Сайн цагийн дуудлага хийгээд бидний мөрөөдөл, эрхэм зорилго бол:**

Эх нутгаа төв, баруун, зүүн гар гэж хуваадаг Монгол төрийн эртний, шалгарсан уламжлалын дагуу Улаанбаатар-Дархан-Эрдэнэт гол төвийн зэрэгцээ баруун зүүн хоёр талдаа хөгжил татах, тэнцвэртэй, хүчирхэг хоёр төвтэй; тэднийгээ зам харилцаа, дэд бүтцээр холбосон; аж үйлдвэр, хөдөө аж ахуйд тулгуурласан; олон улсын болон бус нутгийн хөдөлмөрийн хуваарьт зохих байр сууриа эзэлсэн бие даасан, хүчирхэг, хүн амьдрахад таатай, олон улсад нэр хүндтэй, ирээдүй рүү тэмүүлсэн, Монгол үндэстнээ дээдэлсэн улс гэрийг шинээр цогцлоон байгуулах явдал мөн.

Үүний тулд “Тусгаар тогтнол эв нэгдэл” Эвсэл дараах гурван үндсэн зорилтыг дэвшүүлж байна.



МОНГОЛ  
ҮНДЭСНИЙ АУ

УХАА

№


20 16 он .04.

- МАНАН тогтолцоог хална.** Олон жил халаагүй, хуваарьгүй ноёрхсон МАНАН хэмээх нэг намт, гэмт хэрэгжсэн, бурангуй, дарангуй дэглэмийг ардчилсан, хууль ёсны арга замаар халан өөрчлөх; **Өнөөгийн бурангуй, дарангуй дэглэм Монголын ард түмний итгэл найдварыг бүрэн алдаж, Монгол орныг системийн ужиг хямралд оруулж, авилгад идэгдэж, улс орныг удирдан жолоодох чадвараа бүрэн гээсний улмаас Монгол орныг хямрал сүйрэл рүү хөтөлсөн нь хэн бүхэнд тодорхой.**
- Шударга, хүчирхэг, үндэстний шинэ төр, нийгэм тогтооно.** Монгол үндэстний эрх ашигт нийцсэн, бүх ард түмний өөрийн хүсэл эрмэлзэл, идэвхи, оролцоонд тулгуурласан, шударга бөгөөд хүчирхэг, нэгдмэл бөгөөд Үр ашигтай, зохиролт (гармоник) бөгөөд шударга улс төр-нийгмийн систем шинээр бүрдүүлэх; Бидний 20 гаран жил зорин тэмцсэн “ардчилал” бүрэн эвдрэл гажуудалд орж, түүнээсээ мухардалд шилжсэн нь эдийн засгийн гүн гүнзгий хямрал; нийгмийн замбараагүйдэл; гэмт хэрэгжилт; оюун санааны хоосрол хийгээд хувь хүний хэт аминч, нийт үндэстэнд хөнөөлтэй бэртэгчин үзэл, үйлдэл; нийгмийн “атомжсан” задралаас тод харагдаж байна. Цаашдаа системийн энэхүү алдаа гажуудлыг засч, монгол үндэсний онцлогийг харгалзсан, жинхэнэ, бодат ардчилал тогтоох замаар эдийн засаг, нийгэм, оюун санааны амьдралыг засч сайжруулах.
- Улстөрийн тэргүүлэх хүчнийг зохион байгуулна.** Монгол орны эдийн засаг, нийгэм, оюун санаа, улс төрийн бүх хүрээг иж бүрэн уялдуулсан, алсыг харж нэгэн зорилгод зангиdsan, зорилго чиглэлтэй, системтэй Үндэсний бодлого хэрэгжүүлэх замаар Монголын төр, нийгмийг өнөөгийн сүйрэлт хямралаас гаргаж, хөгжин дэвжүүлэх эрхэм үүрэг бүхий улс төрийн тэргүүлэх хүчнийг бүрдүүлэх 3 үндсэн зорилтыг дэвшүүлж байна.

### ХОЁР. ХЯМРАЛ, ЗАДРАЛ, СҮЙРЛИЙН ШАЛТГААН

Эдүгээ манайд улс төрийн системийн хямрал даамжирч улмаар системийн задрал болон хувирч байна. Монгол орон сүйрэл хямрал руу гулган орж, бууран доройтож буйн үндсэн бөгөөд гол шалтгаан бол олон жил амь бөхтэй оршиж, эрх мэдлийн төлөө зууралдсаар байгаа, олон арван жил халаагүй, хуваарьгүй, хяналтгүй явж ирсэн улс төрийн “нэг намт” МАНАН тогтолцооны ялзрал задрал мөн.

“Нэг намт” гэдэг нь улс төр, бизнесийн явцуу, нэгдмэл эрх ашиг нь нэгэнт ил болсон МАНАН хэмээх эрх баригч намууд, тэдгээртэй угсаа гарвал нэгтэй салбар намуудын өнөөгийн бурангуй дэглэм юм. Харахад хоёр атлаа нэгэн нам болон



далдуур нэгдсэн гаж дэглэм төрийн эрхийг авсан тохиолдолд Үндсэн Хуульд заасан олон намт арчилсан тогтолцоог сүйтгэж байна.

Нэг намт МАНАН дэглэм нийгмийн баялгийг хулгайлах, завших авилгын нэгдмэл сүлжээ болон хувирч, гэмт хэрэгжиж, түүнийгээ төр, нийгмийн амьдралын ердийн хэм хэмжээ болтол хөгжүүлснээр явцуу цөөнхийн дарангуйллыг амь бөхтэй тогтоож, манай үндэстний оршихуйд бодит аюул занал болон хувираад байна.

**Зөвхөн шинэ, дэвшилтэт улс төрийн ТЭРГҮҮЛЭХ ХҮЧИН Монгол орныг, Монгол үндэстнийг улс төр, нийгмийн ноцтой хямралаас гаргаж нэн аюул уршигтай өнөөгийн бурангуй дэглэмийг өөрчилж чадна.**

Бид улс орон, өөрийн болон үр хүүхдийнхээ сайн сайхан амьдрал, ирээдүйн төлөө тэмцэж, авилгач, хуурамч төрийн бурангуй дэглэмийг халан өөрчилж, бодат ардчилалтай, хүн бүр хүсэл эрмэлзлэл, идэвхи зүтгэлээрээ улс үндэстнийхээ амьдралд идэвхтэй оролцоог нээсэн, нийгмийн эрүүл саруул бүтцийг бүрдүүлсэн зохиролт, найралт нийгэмд амьдрахыг хүсч дараах зорилтуудыг дэвшүүлж байна.


## ГУРАВ. БИДНИЙ ДЭВШҮҮЛЭХ ЗОРИЛТУУД

### 1. Улс төрийн хүрээнд:

**ЭМХ ЦЭГЦ, ДЭГ ЖУРАМ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ ТОГТООНО.**

Төрийн застгийн өнөөгийн үр ашигтүй, авилгад идэгдсэн, үрэлгэн дэглэмийг халж, алсын хараатай, “нэг гартаа хуулийн ташуур, нөгөө гарг буяны аяга барьсан”; шинжлэх ухааны судалгаа, тооцоонд тулгуурласан; үндэсний шилдэг боловсон хүчинээс бүрдсэн төрийн албатай; зохион байгуулах болон удирдан жолоодох өндөр чадавхитай; монгол хүнд түргэн шуурхай, хүнд сурталгүй үйлчилдэг; чадварлаг бөгөөд цомхон, далайцтай бөгөөд уян хатан, шуурхай бөгөөд эрч хүчтэй; эмх цэгц, дэг журам, сахилга баттай төрийн болон төрийн удирдлагын тогтолцоо бүрдүүлнэ.

- Олон жил бугшсан МАНАН-гийн бусармаг улс төрийн “чөтгөрийн тойрог”-оос салах шийдвэртэй алхам хийж үндэсний онцлогийг тусгасан бодат ардчиллыг сэргээн тогтооно.
- Ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуулийг өөрчлөх замаар улс төрийн шинэ, шударга, дэвшилтэт тогтолцоо бүрдүүлэхийн төлөө ажиллана.
- Мэргэжлийн чадвар бүхий хүмүүс, эх орондоос бүрдсэн Ард түмний Итгэл найдварын Засгийн Газар байгуулан ажиллахын төлөө тэмцэнэ.
- Боловсон хүчний системд бугшсан ах дүү, хамаатан садан, танил талын болон намын системийг эвдэж, шинэ дэвшилтэт, шударга өрсөлдөөний зарчмыг нэвтрүүлнэ.
- Бүх шатны боловсон хүчний зөвхөн ажлын ур чадвар, хичээл зүтгэл, идэвхи санаачлагаар нь үнэлж дүгнэх систем бий болгож мөрдөнө.
- Бүх шатны боловсон хүчнийг анхан шатнаас эхлэн ажиллах, улмаар ажлын бодит үр дүнгээр албан тушаал ахиулах, нэгэнт ийм системээр тохoon томилогдсон төрийн албан хаагчийн төрд тогтвортой ажиллах тогтолцоог нэвтрүүлж эхэлнэ.



- Төрийн албан хаагчдын мэргэжил, ур чадварыг сайжруулах бодлого баримтална.
- Төрийн өндөр албан тушаалтнуудын авилгатай эрс шийдвэртэй тэмцэнэ.
- Төрөөс иргэнд учруулсан хохирлыг эзэн биетэй болгож, иргээний хохироосон аливаа шийдвэрийг гаргасан, гарын үсэг зурсан хүн хариуцлага шууд хүлээдэг, нөхөн төлбөрийг хариуцдаг эрх зүйн орчныг бүрдүүлнэ. **ОЛ УЛСЫН АУДИТИН ГАЗАР**  
**ХА0122**
- Төрийн бодлого, шийдвэр гаргах явцуу, гэнэтийн, дур зоргийн үйлдлийг таслан зогсоож, зөвхөн шинжлэх ухааны үндэстэй судалгаа, тооцоонд тулгуурлан ажиллах үндэсний систем тогтооно. Үндэсний Хөгжил Стратегийн Судалгааны Хүрээлэн байгуулж ажиллуулна.
- Албан тушаалтны хууль бус, хүнд сурталт дур зоргийн үйлдлийг таслан зогсооно.
- Нэгтэн гаргасан төрийн шийдвэрийг шууд бөгөөд эргэлт буцалтгүй, шуурхай бөгөөд шударга, бүрэн бөгөөд тууштай биелүүлэх бүх талын нөхцлийг бүрдүүлнэ.
- Төрийн нууцаас бусад төрийн аль ч мэдээллийг иргэдэд ил тод болгоно.
- Гэмт үйлдлийн шинжтэй мэдээллийг төрийн нууцад хамааруулах явдлыг таслан зогсоож, олон нийтэд худал болон зөрчилтэй мэдээлэл өгсөн, мэдээллийг нуун дарагдуулсан, хоцроосон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэг болгоно.
- Интернэтэд 60 хоногийн өмнө нийтэлж, нээлттэй хэлэлцүүлэг хийгээгүй хуулийн төслийг УИХ-д хэлэлцэхийг хязгаарлана.
- Улс орны хууль тогтоомжийг нэгдмэл, шударга болгож, хэрэгжилтийг сайтар хангулна.
- Шүүх, хууль сахиулах байгууллагыг улстөрийн нөлөөллөөс ангижруулж, хараат бусаар ажиллах бүх талын нөхцлийг хангах чиглэлд тууштай ажиллана.


## 2. Эдийн засгийн хүрээнд:

**ҮНДЭСНИЙ БОЛОН БОДАТ ЭДИЙН ЗАСГИЙН НЭГДМЭЛ СИСТЕМ БҮРДҮҮЛНЭ.**

Өөр хоорондоо холбоо харилцаагүй, бие биенээ мэдэрдэггүй, салангийн тусгай, Үр ашиг муутай, явцуу цөөнхийн эрх ашигт үйлчилдэг өнөөгийн эдийн засгийн Үрэлгэн тогтолцоог халж, Монгол орныг аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгох эрхэм зорилт бүхий үндэсний болон бодит эдийн засгийн нэгдмэл систем бүрдүүлнэ.

Монголын үндэсний эдийн засаг дараах цогцолборуудаас бүрдэх ба энэ бүхнийг нэгтгэсэн Үндэсний Хөгжлийн шинэ бодлого боловсруулж мөрдөнө. Үүнд:

- а) Улс орныхоо түлш, шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр найдвартай хангаж, экспортын нөлөө бүхий нөөц бүрдүүлэх чадвартай түлш-эрчим хүчний хөгжингүй цогцолбор;
- б) Хүн ардынхаа хүнс, тэжээлийн хэрэгцээг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр найдвартай хангаж, экспортын нөөц бүрдүүлэх чадвартай, уламжлалт болон эрчимжсэн технологийг оновчтой



хослуулсан мал аж ахуй, газар тариалан, жимс ногоо боловсруулах үйлдвэрийн цогцолбор;

в) Мал аж ахуйн түүхий эдийг өөрийн орны болон умард сэргүүн, хүйтэн бус нутаг, Монгол тургатны хэрэгцээнд зориулан өндөр технологиор боловсруулж, сайн чанарын бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадалтай хөнгөн үйлдвэрийн цогцолбор;

г) Эх орныхоо эрдэс түүхий эдийн баялгийг ариг гамтай олборлож, хамгийн үр ашигтай технологийн шатанд хүртэл боловсруулан дотоод хэрэгцээгээ бүрэн хангаж, экспортын тогтвортой эх үүсвэр бүрдүүлэхэд чиглэсэн уул уурхай, металлургийн цогцолбор;


д) Улс орны нийгэм ахуй, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг бүрэн хангаж, дотоод зах зээлээ эзлэх хүчин чадал, технологи бүхий барилгын материал, барилга үйлдвэрлэлийн цогцолбор;

е) Эх орныхоо байгалийн орчин нөхцөл, нүүдэлчдийн соёл, түүхийн дурсгалд түшиглэсэн олон улсын аялал жуулчлалын үндэсний цогцолбор;

ё) Олон улсын стандартад хүрсэн, өндөр хөгжил бүхий банк, санхүүгийн үйлчилгээний тогтолцоо болно.

Бид баялгийг сул тараахгүй, мөн цөөн хүнд завшуулахгүй зарчим баримтлан ажиллана. Үндэсний баялгийн дийлэнх хэсгээс эрх баригч цөөнх завшин баяжиж, иргэдийн олонхид “хусам тараах” зарчим болон баялгийг бүх нийтээрээ тэгш, тэнцүү “хувааж идэх” зарчмуудын аль аль нь буруу гэж бид үзнэ.

- Монголчууд ажиллах хүч, хөрөнгө, хөдөлмөрөө нэгтгэн, хоршоолох, нэгдэх, хамтран ажиллах бүх төрлийн хэлбэрүүдийг дэмжиж төрөөс тусlamж үзүүлэх бодлого баримтална.
- Стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг төрийн өмчид бүхэлд нь хамааруулж, “Оюутолгойн гэрээг шударгаар хянаж, өмнөх эрх баригчдын алдааг үндэсний эрх ашигт нийцүүлэн засахын төлөө ажиллана.
- Таван Толгойнордыг ард түмний өмчид хэвээр үлдээж нийтийн өмчийн хувьцаат компанийн жишиг болгон хөгжүүлнэ.
- Арьс шир, ноос, мах, сүү боловсруулах үйлдвэрлэлийн цогцолборууд болон хүлэмж, загас, загасан бүтээдэхүүний үйлдвэрлэлийг бус нутаг болон орон нутгийн онцлог, өмнө нь гаргаж баталсан төслүүдийг харгалзан барьж байгуулна.
- Мал аж ахуйн материал-техникийн баазыг эрчимтэй хөгжүүлж, таваарлаг чанар, ашиг шимиийг малын тоо толгойгоос илүүтэй анхаарч, малчдын ачааллыг бууруулахын хамт орлогыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авна.
- Үр ашигтай нь нотлогдсон “Шинэ сумын төв” хөтөлбөрийг бусад суманд хэрэгжүүлнэ.
- Газар тариалан, төмс, хүнсний ногоо болон малын тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжиж, гурил, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээг тогтвортой хангах систем бүрдүүлнэ.
- Банк-санхүүгийн системийг ил тод болгож, валют мөнгөний бодлогыг эрүүлжүүлнэ.



- Ипотекийн зээлийн дарамтыг багасгасны үндсэн дээр Орон сууцжуулах хөтөлбөрийг хот, орон нутагт хэрэгжүүлнэ. Төрийн орон сууцны корпорацийн үйл ажиллагааг илүү боловсронгуй, иргэдэд хүртээмжтэй болгоно.
- Банк-санхүүгийн системийн мөнгө хүүлэл болон бүх ~~нийтийн~~ хувирсан өрийн дарамтыг зөөлрүүлэх цогц арга хэмжээ авч, үндэстний эдийн засгийг тэтгэх эрүүл саруул систем болгоно.
- “Бүтээн байгуулалтын фронт” байгуулж, ажилгүй, мэргэжилгүй залуучуудаар түүнд ажиллах хүчинийг бүрдүүлэх<sup>22</sup> хуваарилах, зохион байгуулах, үйлдвэрлэл-сургалтын төвүүдтэй хамтран мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, улмаар өндөр мэргэжилтэй ажилчин, ажилтнууд бэлтгэх үүргийг ногдуулж ажиллана.

**ДИТЫН ГАЗАР**

*ЧСРНХ ФОДЕР*


“Цэвэр бизнес”-ийг хөгжүүлэхийн тулд:

- Бизнесийн салбарын холбоод, хамтын зохицуулалтын институцуудыг хөгжүүлэх, салбарын холбоодод төрийн зарим үүрэг функцийг шилжүүлэх, нээлттэй хувьцаат компаниудыг дэмжин хөгжүүлэх, улс төрийн намуудын санхүүжилт, хандивын тогтолцоог бүрэн ил тод болгох, нарийн чанд хянах арга хэмжээг тэргүүн ээлжинд авна.
- Улс орноос хөрөнгө гадагшлах, “оффшор” эдийн засаг цэцэглэх явдалд хуулийн саад хориг тавина.
- Дэлхийн худалдааны байгууллагаас хоцронгуй хөгжилтэй орнуудад өгдөг худалдааны хөнгөлөлтийг бүрэн ашиглана.
- Үндсэн хуульд заасны дагуу эдийн засаг, зах зээлд төрийн зөв зохистой удирдлагыг бий болгоно. Эдийн засагт зөвхөн хувийн өмч төдий бус мөн улсын, нийтийн өмчийн хэлбэрүүдийг хөгжүүлж зохистой харьцааг хадгална.
- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг хөвөгч биш тогтвортой (fixed) байхаар тогтоож бизнесийн эрсдлийг арилган зах зээлийг тогтвorumуулна.
- Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнол, ард иргэд, ирээдүй хойч үеийн нийгмийн баталгаа болгож нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн олборлолтоос 10 хувийг “Ирээдүй сан”-д төвлөрүүлдэг болно.

### 3. Нийгмийн хүрээнд:


#### НАЙРАЛ-ЗОХИРОЛТ НИЙГЭМ БАЙГУУЛАХЫГ ЗОРИНО.

Нийгэм задран атомжиж, хувь хүний бусаддаа халгаатай хэт аминч үзэл, бэртэгчин зан цэцэглэж, гэмт хэргийн уур амьсгал ноёрхож, хувь хүний болон нийгмийн ёс суртахуун хэт доройтолд орсон өнөөгийн нийгмийг халж, төр нь зохион байгуулалттай, иргэд нь сахилга баттай, оюун санаа нь цэгцтэй зохиролт, найралт энэрэнгүй (гуманист) нийгэм байгуулах зорилт тавьж байна.



Энэ нь амжиргааны хангалуун түвшинтэй, боловсрол, эрүүл мэндийн бодат баталгаатай, нийгмийн халамж, хамгаалал бүрдсэн, гэмт хэргээс ангид, айх аюулгүй, ёс суртахууныг дээдэлсэн, хүн хүнээ хайлладаг, шударга хөдөлмөрийг дээдэлдэг, хамтач, сахилга бат, эмх цэгц, зохион байгуулалттай найралт, зохиролт нийгэм байгуулна гэсэн хэрэг юм.

- Монголын нийгэм, үндэстэн “бүхнийг хүүхдийн төлөө” гэсэн зарчмын дагуу ажиллах бүх талын анхдагч нөхцөл бүрдүүлэх ба энэ эрхэм зарчмыг манай нийгэм, үндэстний тулгамдсан бөгөөд стратегийн зорилго нэгэн зэрэг болгоно.
- Салангийн тусгай, өөр хоорондоо уялдаагүй, хэт замбараагүй олон бодлого, бодлогын баримт бичгүүд бидний ажилд тус болохогоосоо саад болох нь элбэг учир эмэгтэйчүүдийн, хүүхдийн, залуучуудын, гэр бүлийн, ахмад настны, эмзэгжлийн, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт хэт олон бодлогын баримт бичгүүдийг нэгтгэн системчилж, уялдаа холбоог сайжруулж “Монгол гэр бүлийн төлөө” нэгдсэн бодлого болгож хэрэгжүүлнэ.
- Чанартай боловсрол эзэмших, эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах, гэр бүлийн үнэт зүйлийг бэхжүүлэх талаар залуучуудад чиглэсэн төрийн бодлого боловсруулах.
- Авьяас чадварыг хөхиүлэн дэмжихээс гадна залуу эрдэмтдийн ирээдүйтэй төслийг дэмжинэ.
- Хотоос хөдөөрүү чиглэх нүүдлийг хөхиүлэн дэмжих, хөдөөнөөс хот руу чиглэх нүүдэлд тодорхой шалгуур тавих замаар хүн амын хэт төвлөрлийг сааруулж тэнцвэржүүлсний үндсэн дээр хөдөөг эзгүйрлээс, хотыг хорт утаа, өвчлөлөөс салгах үе шаттай бодлого хэрэгжүүлнэ.
- Иргэдийн гэр бүлээрээ хамт байх бүхий л бололцоог дэмжиж, клуб, урлаг, спортын секцii, боловсролын, жуулчлалын төвүүд, цэцэрлэгт хүрээлэнгийн сүлжээг бий болгох, ийм төрлийн бүтээн байгуулалтад хөрөнгө оруулж байгаа хувийн хэвшлийг дэмжих бодлого баримтална.
- Залуу хүн бүр урлаг, спорт, шинлэх ухааны туурвилийн аль нэг буюу эдгээрээр зэрэг хичээллэх явдлыг бүх нийтийн журам болгоно.
- “Бүх хүнд чанартай бөгөөд тасралтгүй боловсрол” олгох хөтөлбөр хэрэгжүүлж эхэнэ.
- Монгол үндэстэн өөрөө өөрийгөө хорлох нэгэн гол эх булаг болсон эмийн хэрэглээг хяналттай болгоно. Ямар ч хараа хяналтгүйгээр элдэв төрлийн антибиотик, эм бэлдмэл “иддэг” гаж, хорт зуршлын эсрэг Эрүүл мэндийн хяналтын шинэ тогтолцоо бүрдүүлнэ.
- Эрүүл мэндийн шугамаар гадагшаа урсаж байгаа мөнгөн урсгалыг дотооддоо үлдээхийн тулд анагаах ухааны салбар тус бүрээр чадвартай эмч нарыг цуглуулан, эмч нарын баг тус бүрт суурилсан тусгай төсөл санаачилж төрөөс бодлогоор дэмжиж хөгжүүлнэ.
- Олон жилийн турш сул анхаарч, орхигдуулж ирсэн гэмт хэрэгтэй тэмцэх явдлыг бүх нийтийн үйл хэрэг болгоно. Гэмт хэргийн эсрэг Үндэсний цогц хөтөлбөр боловсруулж, гэмт хэргийг жигшин үздэг уур амьсгал, орчин бүрдүүлэх эхлэлийг тавина.



#### 4. Оюун санааны хүрээнд

### **МЭДЭЭЛЛИЙН ТЕРРОРИЗМААС ИРГЭДИЙНХЭЭ ОЮУН САНААГ ХАМГААЛНА**

- Үндэсний-эх оронч үзлийг төрийн үзэл суртлын нэгэн гол чиглэл болгоно.
- Монголын түүх, монгол хэл, бичиг, Монголын уран зохиолын хичээлийн үнэлэмжийг дээшлүүлж, төрийн албан хаагчдаас эдгээр хичээлээр шалгалт авдаг болгоно.
- “Бүх нийтийн эх оронч үзлийн” цогц хөтөлбөр боловсруулж, хуухэд залуу үеийг үндэсний- эх оронч үзлээр хүмүүжүүлэх систем бий болгоно.
- Хувь хүнийг нийгэм, гэр бүл, хамт олноос нь салгадаг, Монгол иргэншил, соёл, суртахуунд харш бөгөөд халгаатай шашны тэrs урсгалуудын хориглох бодлого хэрэгжүүлж эхэлнэ.
- Шинжлэх ухааны болон соёлын бодлогыг шинэчлэн боловсруулж, шинжлэх ухаан, соёл урлагийн бүтээлийг сурталчлах, үнэлэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
- Биеийн тамир, спортыг хөхиүлэн дэмжихийн хамт хуучны “Хөдөлмөр, батлан хамгаалахад бэлэн” бүх нийтийн хөдөлгөөнийг сэргээн хөгжүүлнэ.
- Интернэт, олон нийтийн сүлжээгээр тодорхой нэр, хаягчийгээр бусдыг гутгэх, гутаан доромжлохыг хуульчилж, хүчирхийлэл, садар самуун, гаж үйлдэл зэргийг өдөөгч мэдээллийн терроризмыг таслан зогсоно.

#### 5. Батлан хамгаалах, гадаад бодлогын хүрээнд:


Хоёр хөрш болон бүс нутгийн орнуудтай эрх тэгш, найрсаг харилцаа тогтоож, дэлхийн улс төр, эдийн засгийн интеграци, олон улсын хөдөлмөрийн хуваарьт зохих байр сууриа эзэлж, Эх орноо болзошгүй аюул заналаас хамгаалахад чиглэсэн цэргийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар найрсаг энх тайван гадаад орчин бүрдүүлэхийг зорино.

- Хоёр хөрш, тэргүүлэх чиглэлийн орнууд гэсэн чиглэлийг баримталж, эхлээд бүс нутгийн, дараа нь дэлхийн түвшний бодлого гэсэн дэс дарааллыг гадаад бодлогодоо баримтална.
- Өнөөгийн геополитикийн сэргэлдөөн зөрчил, дэлхийн эдийн засгийн хямрал зэргээс шалтгаалан Монгол Улс “төвийг сахих” бодлогыг баримтлах боломжгүй гэж үзнэ.
- Батлан хамгаалах салбарыг хүчирхэгжүүлэх бодлого баримтална.

#### 6. Байгаль экологийн хүрээнд


**АШИГТ МАЛТМАЛЫН ОРДУУДАА ДЭС ДАРААТАЙ, ҮЕ ШАТТАЙ АШИГЛАЯ.**

Байгалийн баялгаа зохистой, үр ашигтай, нийтэд хүртээлтэйгээр ашиглахдаа байгалийн тэнцвэрт байдлыг хангах, түүхийн дурсгалт газраа хадгалан үлдэх, уламжлалт соёл иргэншлийнхээ байгальд ээлтэй дэвшилтээ шинжийг



хадгалсан хариуцлагатай ногоон эдийн засгийн бодлогыг төрийн бодлого болгон хэрэгжүүлнэ.


- Монгол орныхоо байгалийг унаган төрхөөр нь хадгалан хамгаалж, баялгаа хойч үедээ өвлүүлж ирсэн үндэсний уламжлалаа шинэ цагийн “экологид эвсэг” хөгжлийн үзэл баримлалтай уялдуулсан хөгжлийн бодлогоороо дэлхийд тэргүүлэх зорилго тавин ажиллана.
- Ургамал, амьтны аймгийн нөөцийн хомсдлыг хязгаарлаж байгалийн жамаар нөхөн үржих орчныг хамгаалж, тэдгээрийг тогтвортой ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.
- Хүний ёсонд үл нийцэх амьтны амь таслах ангийн аялал жуулчлалыг нийгэм, эдийн засаг, байgal орчныг хамгаалах бодлоготой нягт уялдуулна.
- Экосистемийн нэгдмэл байдал, биологийн төрөл зүйлийг хадгалан хамгаална.
- Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хэвийн өсөлтийг хангах, зориудын аргаар үржүүлэх, генийн санг хамгаалахад биотехнологийн ололтыг ашиглаж биологийн найдвартай нөөцтэй болно.
- Олон улс, бус нутгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах бодлого, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын зэрэгцээ Монгол улсын газар нутгийн 30 хүртэлх хувийг Улсын тусгай хамгаалалтад авах төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- Хүрээлэн буй орчинд хор нөлөө өндөртэй үйлдвэрлэл, үйл ажиллагааг хугацаа болон ашиглалт, стандартын шаардлагаар хязгаарлах бодлого баримтлана.
- Байгаль орчныг “бохирдуулагч нь төлөгч”, “ашиглагч нь хамгаалагч” байх үзэл санааг хэрэгжүүлнэ.
- Говь, хээрийн бусэд мод тариалж ногоон зурvas байгуулах “Ногоон хэрэм” хөтөлбөрийг үргэлжлүүлж, ойн сангийн 20 хүртэлх хувийг нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэн ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах хариуцлагын тогтолцоо боловсронгуй болгоно.
- Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцлийг хангах “Ой” үндэсний хөтөлбөрийг идэвхтэй дэмжинэ.
- Газар зүйн мэдээллийн тогтолцоонд сууринсан ойн мэдээллийн сан байгуулна.
- Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах “Ус” үндэсний хөтөлбөрийг дэмжинэ. Гүний цэвэр усыг үйлдвэрлэлд шууд ашиглаж байгаа үрэлгэн байдлыг халахад нэн тэргүүнд онцгой анхаарна.



- Ус цэвэршүүлэх байгууламжийг шинэчлэн дэвшилтэт технологийг ашиглан саарал усыг үйлдвэрлэл, дэд бүтцийн зориулалтаар дахин ашигладаг болгох ажлыг даруй зохион байгуулна.
- Гол мөрний ай савыг ойжуулах ажлыг нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлнэ. **ДИТЫН ГАЗАР**
- Туул голын экосистемийг сэргээн хамгаалж, Тэрэлж орчмын хэсэгт цөөрөм байгуулах замаар нийслэлийн ундны усны хангамжид гадаргын **усыг** ашиглах боломжийг бүрдүүлнэ.
- Улаанбаатар хотын экосистемийн хямрал буюу агаар, хөрс, усны бохирдлыг зогсоох цогц бодлого боловсруулна. **! 80%**
- Эдийн засгийн тооцоо судалгаанд үндэслэн ашигт малтмалын **ордуудад дээс дараатай**, үе шаттай ашиглах замаар байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалах бодлогыг тууштай баримтална.
- Монгол орны байгаль-экологийн тэнцвэрт байдалд шийдвэрлэх нөлөөтэй бүс, газар нутгийг судалгаагаар тогтоож, тухайн бүс нутагт ашигт малтмал хайх, олборлохыг хуулиар хориглоно.
- Ногоон, экологийн үйлдвэрлэлийг бүхий л талаар дэмжих бодлого баримтална.
- Залуу үед экологийн боловсрол олгох ажлыг онцгойлон авч үзэж, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, чанаржуулах ажлыг зохион байгуулна.

**“НЭГДМЭЛ АРД ТҮМЭН ЯЛАГДАШГҮЙ !!!” ХЭМЭЭСЭН “ТУСГААР ТОГТНОЛ ЭВ НЭГДЭЛ” ЭВСЛИЙН “АРД ТҮМНИЙ ИТГЭЛ НАЙДВАР” МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ САЙТАР УХААРЧ, УЛАМ УЛАМ ТАРААГТУН !**

2016 оны 5 дугаар сар.





СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016.04.24 № 801  
танай -ны № -т

**Нийцлийн талаарх дүгнэлт**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцох бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Тусгаар тогтнол эв нэгдэл эвслийн /Тусгаар тогтнол, Эв нэгдлийн нам, Монголын ногоон нам/ "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд эвслийн боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Тусгаар тогтнол эв нэгдэл эвслээс ирүүлсэн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-ийг Аудитын Дээд Байгууллагудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

**Дүгнэлт**

Тусгаар тогтнол эв нэгдэл эвслийн Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Тусгаар тогтнол эв нэгдэл эвсэлд

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

000028